

**Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны
07 дугаар сард хийсэн ажлын товч мэдээ**

2023 оны 7 дугаар сарын 20

Дархан-Уул аймаг

Тус албаны 3 албан хаагч ээлжийн амралттай, 3 албан хаагч ажиллаж байна. Дотоод аудиторын сул 2 орон тоог нөхөх тусгай шалгалт зарлагдсан ба зарыг албаны цахим хуудас болон фэйсбүүк хуудсаар мэдээлж байна.

Аймгийн Засаг даргын баталсан тус албаны 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021-2022 оны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж дууссан ба материалыг холбогдох байгууллагад хүргүүлсэн. Шалгалтаар тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг илүү дутуу тооцон олгосон, 5 жилд олгох тэтгэмжийг буруу тооцон илүү дутуу олгосон, шатахууны үнэ, эмчилгээ үйлчилгээний төлбөр төлүүлэх, хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлэх, төлбөртэй үйлчилгээний орлого төлүүлэх, урамшуулал төлүүлэх зэрэг илэрсэн зөрчилд 30,2 сая төгрөгийн 7 акт тогтоож, зөрчил арилгуулах тухай Улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлагыг хүргүүлсэн.

Мөн Дархан сумын 31-р цэцэрлэгийн 2021-2022 оны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж дуусган Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааг холбогдох ажилтан албан хаагчтай хийж байна.

Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газрын 2021-2022 он, Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв ААТҮГ-ын 2022 оны үйл ажиллагааны баримтад тус тус дотоод аудит хийж байна.

Тус албанд ирүүлсэн хугацаатай мэдээ тайланг холбогдох газарт нь хугацаанд хүргүүллээ. Үүнд:

Албаны бүтэц, орон тоо, эрх зүйн үндэслэл, чиг үүргийн талаарх мэдээллийг гаргаж ХЭЗХ-т цахимаар хүргүүлсэн.

Сангийн яамны Дотоод аудитын хорооны 2022 оны 14 дүгээр тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар хавсралтаар гарган Сангийн яамны СХЭУГ-т цаасаар болон цахимаар хүргүүллээ.

Мөн тус албаны 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон тоон тайланг гарган Сангийн яамны СХЭУГ-т цахимаар хүргүүлэв.

Албаны даргын ээлжийн амралттай хугацаанд орлон гүйцэтгэж буй дотоод аудитор А.Сандагдорж аймгийн Удирдах ажилтны хуралд оролцож Шилэн дансны 3-р улирлын тайлан илгээхтэй холбоотой мэдээлэл өгсөн.

Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээ 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдсан ба тус албаны дотоод аудитор Ш.Отгон төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөж, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Батхуяг төрийн албан хаагчийн дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтыг амжилттай төгссөн сертификатаа авлаа.



Тулгар төрийн 2232, Их Монгол Улсын 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ойн баяр наадмын нээлтэд албан хаагчид оролцлоо.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА